



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрмэн сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2022/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Өмнөговь аймаг  
Даланзадгад сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [tserenbayars@audit.gov.mn](mailto:tserenbayars@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [khongorzult@audit.gov.mn](mailto:khongorzult@audit.gov.mn)

Аудитор: Ч.Наранбадрах  
Утас: 70005329 Цахим хаяг: [Naranbadrakhch@audit.gov.mn](mailto:Naranbadrakhch@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.22 № 110

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХҮРМЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.ТУУЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Хүрмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-22 №110 07

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	47.9	107.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	719.3	752.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>767.3</b>	<b>860.1</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	767.3	8.4
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>767.3</b>	<b>860.1</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	468.4	695.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	416.5	602.4
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>		
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>		
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
	Тайлант оны үр дүн		
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>767.3</b>	<b>860.1</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	354.7	459.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0</b>	<b>0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>0</b>	<b>1.5</b>
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		<b>376.0</b>
	Урсгал зардал		376.0
	Хөрөнгийн зардал		0
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		<b>377.6</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		31.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүрмэн сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн заслын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага юм.

### Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Дөрөв. Аудитын гол асуудал



Тус байгууллага нь үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8 ширхэг үндсэн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийг актлах, устгах, зарим ашиглах боломжтой үндсэн хөрөнгөнд үнэ тогтоох саналыг дээд шатны газартаа хүргүүлсэн байна.

### Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

#### 5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 27,025,800 төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, 144 мэдээлэл байршуулсны 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

#### Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 27.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

#### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								

#### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс /сая төгрөг/			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж



Хүрмэн сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүрмэн сумын ЭМТ	4	27.6	0	0	-	-	1	0.6	3	27.6